



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 3 сарын 17 өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

А.Ундрахад сахилгын шийтгэл ногдуулах тухай

Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1, Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Албан тушаалтан өөрт ноогдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ын 1.3, 1.4, 1.6, Авлигатай тэмцэх газрын 2016 оны 01/1584 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргаа, хүний нөөц, сургалтын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Алтангэрэлийн Ундрах нь Төрийн албаны тухай хуулийн 13.1.10, Авлигын эсрэг хуулийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.3-д заасныг зөрчиж, хуульд заасан хугацаанд мэдүүлгээ гаргаж өгөөгүй тул "сануулах" сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. А.Ундрахад сахилгын шийтгэл ногдуулах тухай тушаалыг нийт албан хаагчдад уншиж танилцуулан, тушаал гарсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор нийтэд мэдээлэхийг Тамгын газар П.Алтан-Од-т үүрэг болгосугай.

3. Сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд хүргэхэд гарсан зардлыг А.Ундрахаар төлүүлэхийг Санхүү, хангамжийн алба /Б.Цацрал/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЦЭЖАЦАГДОРЖ



000212